



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, И-мэйл: info@mfa.gov.mn,
Вэбсайт: www.mfa.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

2020.01.17 № 13/304
танай _____-ны № _____-т

Биелэлт хүргүүлэх тухай

Гадаад харилцааны яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн дүнг гаргаж, холбогдох баримт бичгийн хамт хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт:

1. Танилцуулга - 2 хуудастай,
2. Хэрэгжилт - 1 хуудастай,
3. Гадаад харилцааны сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсэн тэмдэглэл - 2 хуудастай.



Д.ЦОГТБААТАР

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

ТАНИЛЦУУЛГА

2020 оны 1 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөний биелэлтийн тухай

Гадаад харилцааны яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ы дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргаж, биелэлтэд явцын үнэлгээ хийв.

ГХЯ-ны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 225 ажил, арга хэмжээ тусгагдсан.

Төлөвлөгөөний хэрэгжилт өнгөрсөн оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 94.17 хувьтай байна.

Төлөвлөгөөний биелэлтийн хувиар дор үзүүлэв.

№	Биелэлтийн дүн хувиар	Төлөвлөсөн ажил, арга хэмжээний тоо
1.	100 хувь (үр дүнтэй)	170
2.	70 хувь (тодорхой үр дүнд хүрсэн)	41
3.	40 хувь (эрчимжүүлэх шаардлагатай)	0
4.	0 хувь (үр дүнгүй)	-
5.	Үнэлэх боломжгүй	14
Нийт арга хэмжээний тоо		225
Хэрэгжилт /хувиар/		94.17

Газар, нэгжийн ажил, арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувийг үзүүлэв.

№	Газар, нэгж	100 хувь	70 хувь	40 хувь	0 хувь	Үнэлэх боломжгүй	Нийт	Тайлбар
1.	БТГ	26	1	-	-	1	28	98.88
2.	ХөОГ	7	1	-	-	1	9	96.25
3.	ЕГ	16	8	-	-	1	25	90
4.	АНДОГ	20	1	-	-	4	25	98.57
5.	АОДАГ	11	1	-	-	2	14	97.5
6.	ОТХАГ	10	-	-	-	1	11	100
7.	ГХЭЗХАГ	18	9	-	-	3	30	90
8.	ТЗУГ	10	2	-	-	-	12	95
9.	ОУГЭЗГ	7	2	-	-	-	9	93.33
10.	КГ	15	10	-	-	-	25	88
11.	ГССХГ	24	3	-	-	1	28	96.66
12.	ДЭГ	-	-	-	-	-	-	-
13.	ХШУДАГ	6	3	-	-	-	9	90
Нийт		170	41	-	-	14	225	94.17

Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд “үнэлэх боломжгүй” ажил, арга хэмжээний тоо өмнөх оныхоос 12 арга хэмжээгээр багассан байгаа нь төлөвлөлтийн ажилд бага зэрэг ахиц гарч байгааг илтгэж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. 2020 онд “үнэлэх боломжгүй” гэсэн ажил, арга хэмжээний тоог эрс багасгах, улмаар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө гүйцэтгэлийн боломжийг сайтар урьдчилан харж төлөвлөх;

2. 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан дээд, өндөр хэмжээний айлчлал, зарим арга хэмжээ гаднын хүчин зүйл, хүндэтгэн үзэх шалтгаанаар тухайн онд хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн ажил, арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хугацааг дахин нягтлах, эсхүл төлөвлөгөөнөөс хасаж баталгаажуулах;

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ